



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Бууны албан татварын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

#### Ажлын хэсгийн ахлагч:

О.Баасанхүү -Улсын Их Хурлын гишүүн

#### Гишүүд:

Ж.Батзандан -Улсын Их Хурлын гишүүн  
З.Баянсэлэнгэ -Улсын Их Хурлын гишүүн  
Д.Ганбат -Улсын Их Хурлын гишүүн  
Д.Лүндээжанцан -Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ж.Баярцэцэг -Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга  
Э.Түвшинжаргал -Хууль зүйн байнгын хорооны Ахлах зөвлөх  
Ч.Ариунхур -Хууль зүйн байнгын хорооны зөвлөх  
Г.Оюунболд -Хууль зүйн яамны Хууль сахиулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга

- Б.Гантуяа -Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын мэргэжилтэн;
- Э.Онон -Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын ахлах мэргэжилтэн;
- О.Гэрэл -Соёл, спорт, аялал жуучлалын яамны Биений тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн;
- Л.Энхболд -Эдийн засгийн хөгжлийн яамны Худалдааны хэлтсийн мэргэжилтэн;
- П.Энхтогтох -Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын дарга, цагдаагийн хурандаа;
- Т.Лхагвадорж -Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын ахлах байцаагч, цагдаагийн хошууч;
- М.Чинбат -Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Галт зэвсгийн мэргэшсэн шинжээч, цагдаагийн дэд хурандаа;
- Ч.Алтанхуяг -Эрүүгийн цагдаагийн газрын чиглэлийн ахлах төлөөлөгч, цагдаагийн ахмад;
- Л.Ганбаяр -Тагнуулын ерөнхий газрын Сөрөх тагнуулын газрын хэлтсийн орлогч дарга, хошууч;
- П.Одонбаатар -Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн байцаах хэлтсийн орлогч дарга, хурандаа;
- Ч.Батбямба -Хууль зүйн байнгын хорооны референт.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ